



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/105

Чингис хот

Коронавирусын гамшгийн эрсдэлийн үнэлгээ
хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 заалт, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн чиглэл, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө, Шадар сайдын 2017 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан эрсдэлийн үнэлгээний аргачлалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн хэмжээнд шинэ коронавируст халдварын эрсдэлийг үнэлэх, дэгдэлт үүссэн тохиолдолд аж ахуй нэгж, байгууллага бүр халдварыг даван туулах чадавхийн үнэлгээг хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ц.Гэрэлмаа	Эрүүл мэндийн газрын дарга
Нарийн бичиг:	Т.Мөнхчимэг	Онцгой байдлын газрын гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, хариуцсан мэргэжилтэн дэслэгч
Гишүүд:	Б.Сүнгээ	Мэргэжлийн хяналтын газрын дарга,
	Б.Батсайхан	Цагдаагийн газрын дарга Хурандаа
	С.Мөнхцэцэг	Боловсрол, соёл урлагийн газрын дарга
	Г.Наранхүү	Зооноз өвчин судлалын төвийн дарга
	Б.Бат-Эрдэнэ	Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч Ахлах дэслэгч
	О.Баярмагнай	Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч Ахмад

2. Гамшгийн эрсдэлийн үнэлгээг 2020 оны 02 дугаар сарын 23-ны дотор багтаан хийж дуусгахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

7-10-97

2.

3. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлд танилцуулж, удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Гэрэлмаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА